



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/21

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Цэгцүүлэн дом” өрхийн Эрүүл мэндийн төвийн даргатай гурвалсан гэрээ байгуулан, гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Бор-Өндөр сумын Засаг дарга /П.Чинбат/-ыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсонтой холбогдуулан хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн ажил үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Бор-Өндөр сумын Засаг дарга /П.Чинбат/-д үүрэг болгосугай.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахагван/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010078